

МОНГОЛ УЛС
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

БАТЛАВ:

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ДЭД САЙД

Д.ЗАГДЖАВ

2020 оны 2-р сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 2020/18

**ХОВД-2020 ТАЛБАЙД 2020-2023 ОНД ГҮЙЦЭТГЭХ
1:200000-НЫ МАСШТАБЫН АГААРЫН ГЕОФИЗИКИЙН 5 СУВГИЙН
/СОРОНЗОН, УРАН, ТОРИ, КАЛИ, НИЙЛБЭР/
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР**

Судалгааны үе шат:	1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгаа	
Судалгааны талбайн нэр:	Ховд-2020	
Ашигт малтмалын төрөл:	Бүх төрлийн ашигт малтмал	
Судалгааны талбайн байршил:	Баян-Өлгий аймгийн Алтай, Дэлүүн, Булган сумдын нутагт, Ховд аймгийн Ховд, Дуут, Чандмань, Мөнххайрхан, Зэрэг, Булган, Үенч, Мөст, Цэцэг сумдын нутагт, Завхан аймгийн Урғамал, Сантмаргац, Эрдэнэхайрхан, Улиастай, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Дөрвөлжин сумдын нутагт, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Алтай, Шарга, Дарви, Манхан сумдын нутагт.	
Судалгааны талбайн хэмжээ:	104,044.0 кв.км	
Координат:	48' 00' 00"	Улсын хил
	48' 00' 00"	97' 00' 00"
	46' 00' 00"	97' 00' 00"
	46' 00' 00"	Улсын хил
Хавтгай:	L-45-VI, L-46-I, II, III, IV, V, VI, VII, VIII, IX, X, XI, XII, XIII, XIV, XV, XVI, XVII, XVIII, L-47-I, VII, XIII.	
Код:	Ховд-2020	

1. Геологийн даалгавар өгөх үндэслэл:

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-ын 2.1.4 дэх хэсгийн 1 дэх зорилт, Улсын Их Хурлын 2014 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-ын 3.2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.59 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 5.1 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны А/254 дүгээр тушаалаар баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөө"-ний хүрээнд 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны ажлыг эдийн засгийн бүсчлэл, дэд бүтэц, ашигт малтмалын хэтийн төлөв, металлогенийн бүсийг үндэс, суурь болгох замаар хэрэгжүүлнэ.

2. Судалгааны ажлын үндэслэл:

Судлагдсан түвшин: Судалгааны талбайд 1983-1986 онд А.А.Раузер, 1984-1987 онд Л.В.Заботкин, 1996-1997 онд С.Бөхбат нарын хийсэн 1:200000-ны масштабтай геологийн зураглал, 2013 онд Б.Доржсүрэн, Д.Болортуяа, Д.Гансүх, Ц.Долгион нарын хийсэн 1:200000-ны масштабтай геологийн зураглал ерөнхий эрлийн ажил, 1987-1988 онд Б.Баяндорж нарын, 1989-1990 онд хийсэн 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн соронзон орны зураглал, 1995 онд Д.Тогтох нарын 1:200000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил, 2004-2006 онд Б.Өнөрбаяр нарын 1:200000-ны масштабтай хүндийн хүчний орны судалгааны ажилд хамрагдсан.

Геологийн тогтоц: Төслийн талбайн хэмжээнд өмнөх судалгааны ажлаар неопротерозой Дулаанхар формац, палеопротерозойн Ихганга формац, неопротерозой кембрийн Цул-Уул формац, кембрийн Майхант, Борбургас, Живэрт формац, силурийн Үенч, Эрдэнэбүрэн, Захчин формац, силур-девоны Биж формац, девоны Ойгор, Хүйтэн, Сагсай, Хатуу гол, Цахир боом, Хулманнуур, Цагааншороот, Хүрэн-Уул формац, карбоны Нарийнгол, Тэнгэрт, Хүрэнгол формац, ордовикийн Алаг-Уул формац, юрийн Жаргалант, Дарви, Ихэснуур формац, цэрдийн Гурван-Эрээн, Зэрэг формац, неогенийн Өөш формац, дөрөвдөгчийн хурдас чулуулгууд ялгагдсан байна.

Интрузив чулуулгийн хувьд түрүү анх төрмөлийн интрузивүүд, магнаг судал, цахир, түрүү девоны Нөмрөгийн цогцолбор интрузивууд, түрүү карбоны интрузивүүд, түрүү пермийн Тонхилын цогцолбор интрузивүүд, дунд рифейн интрузивүүд, субвулкан чулуулгийн хувьд түрүү девоны субвулкан бүрдэл, дунд хожуу карбоны субвулкан бүрдэл, түрүү пермийн субвулкан бүрдэл шүлтлэг найрлагатай түрүү пермийн субвулкан бүрдэл дундлаг найрлагатай чулуулгууд ялгагдсан байна.

Ашигт малтмал: Судалгааны талбай нь металлогений мужлалаар Өмнөд Монголын металлогений их мужид (Б.Гантөмөр Ц.Гүндсамбуу. 1996 он) хамаарагдана. Талбайн хэмжээнд өмнөх шатны судалгаагаар чулуун нүүрс, хүрэн нүүрс, алт, зэс, төмөр, молибдени, никель, хөнгөн цагаан, вольфрам, цагаан тугалга, берилли, алт, мөнгө, жонш, барилгын материалын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон. 1:200000-ны масштабын хавтгай тус бүрээр авч үзвэл:

L-46-I хавтгайд нүүрс-1 орд, хайрга-1 орд, шохойн чулуу-1 илрэл, тоосгоны шавар-2 илрэл, термаль рашаан-2 илрэл, вольфрам-12 эрдэсжсэн цэг, хартугалга-1 эрдэсжсэн цэг, зэс-69 эрдэсжсэн цэг, алт-10 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-II хавтгайд шохойн чулуу-3 орд, боржин-1 орд, хайрга-1 орд, полиметал-1 илрэл, полиметаллын-2 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-III хавтгайд хүрэн нүүрс-1 орд, чулуун нүүрс-1 илрэл, эрдсийн будаг-1 илрэл, шохойн чулуу-1 илрэл, алтны-1 илрэл, зэс-13 эрдэсжсэн цэг, никелийн-1 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-IV хавтгайд зэс-4, зэс-алт-1, молибден-1, берилли-1, ниоби-молибден-1, алт-1, балчулуу-1, шохойжин-1, жонш-1 ордтой, мөнгө-2, төмөр-2, кобальт-1, зэс-19, зэс-мөнгө-3, зэс-алт-1, зэс-вольфрам-2, хартугалга-3, зэс-никель-2, хартугалга-зэс-2, хартугалга-цайр-1, хартугалга-вольфрам-1, мышъяк-1, цайр-мөнгө-1, молибден-1, барит-1, циркон-висмут-1, алт-8, циркон-ниоби-1, ниоби-1, циркон-газрын ховор металл-1, цайр-3, германий-1 эрдэсжсэн цэгүүдтэй, хартугалга-5, иттри-2, титан-1, цайр-2, кобальт-2, зэс-2, манган-1, хром-1, циркон-7, ниоби-1, молибден-2 гэсэн сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-V хавтгайд зэс-алт-1 орд, төмөр-1, төмөр-манган-1, ванади-1, зэс-1, зэс-цайр-1, хартугалга-2, балчулуу-2, тальк-1, гипс-1 илрэл, цагаантугалга-5, молибден-9, хром-7, хартугалга-2, манган-1, кобальт-3, циркони-1, иттри-1, лити-1, никель-2, висмут-1 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-VI хавтгайд хоолны давс-2 орд, мөсөн шүү-2, төмөр-1, зэс-1 илрэл, зэс-1, мөнгө-1 эрдэсжсэн цэг, кобальт-3, цайр-2, манган-1, титан-1, ванади-1 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-VII хавтгайд алтны шороон ордын илрэл-1, хартугалга-3 илрэл, молибден-1 илрэл, зэс-4 эрдэсжсэн цэг, берилли-4 эрдэсжсэн цэг, алт-9 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-VIII хавтгайд алт-2 илрэл, зэс-4 илрэл, вольфрам-2 илрэл, молибден-1 эрдэсжсэн цэг, хартугалга-6 эрдэсжсэн цэг, берилли-2 эрдэсжсэн цэг, алт-7 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-IX хавтгайд давс-1 орд, төмөр-2 илрэл, вольфрам-1 илрэл, зэс-алт-1 илрэл, гөлтгөнө-1 илрэл, шавар-1 илрэл, шохойн чулуу-2 илрэл, цайр-1 эрдэсжсэн цэг, мышъяк-1 эрдэсжсэн цэг, цагаан тугалга-1 эрдэсжсэн цэг, зэс-14 эрдэсжсэн цэг, алт-8 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-X хавтгайд чулуун нүүрс-1 орд, чулуун нүүрс-4, зэс-6, боксит-1, натрийн давс-1, будгийн шавар-1 илрэлтэй, төмөр-мөнгө-1, манган-16, зэс-39, зэс-мөнгө-12, зэс, цайр-2, хартугалга-5, хартугалга-цайр-1, цайр-1, вольфрам-3, вольфрам-мөнгө-2, цагаантугалга-1, молибден-1, мышъяк-4, алт-2, алт-зэс-6, мөнгө-2 эрдэсжсэн цэгтэй, кобальт-1, зэс-2, хартугалга-5, магнетит-3, мөнгө-4, ванади-1, хром-11, цагаантугалга-20, лити-1, зэс-36, мышъяк-3, вольфрам-5, никель-1, цайр-7 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-XI хавтгайд орд байхгүй, цагаан хаш-1, элс-1 илрэлтэй, зэс-10, кобальт-1, мышъяк-2, цайр-3, хартугалга-2, молибден-4, алт-8, мөнгө-3, циркон-7, барит-4 эрдэсжсэн цэг, цагаан тугалга-6, молибден-9, хром-13, лити-1, иттри-1, ванади-3, мөнгө-2, циркон-1 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-XIII, XIV хавтгайд хайрга-1 орд, төмөр-2, зэс-1, берилли-7, зэс-алт-1, элс-1, шохойн чулуу-1 илрэлүүд, хартугалга-2, вольфрам-1, алт-34, зэс-6, берилли-22 эрдэсжсэн цэгүүд тогтоогдсон.

L-46-XV хавтгайд алтын шороон орд-1, гялтгануур-1 орд, цайр-1 илрэл, мышъяк-1 илрэл, вольфрам-цагаантугалга-2 илрэл, вольфрам-6 илрэл, хартугалга-берилли-1 илрэл, мөнгө-хартугалга-1 илрэл, хартугалга-1 илрэл, зэс-алт-1 илрэл, зэс-8 илрэл, хром-1 илрэл, берилли-тантани-1 илрэл, берилли-никель-1 илрэл, алт-зэс-1 эрдэсжсэн цэг, алт-24 эрдэсжсэн цэг, алт-мөнгө-1 эрдэсжсэн цэг, алт-хартугалга-1 эрдэсжсэн цэг, мышъяк-1 эрдэсжсэн цэг, хартугалга-мөнгө-1 эрдэсжсэн цэг, тальк-3 эрдэсжсэн цэг, бал чулуу-2 эрдэсжсэн цэг, серпинтин-2 эрдэсжсэн цэг, сарнилын хүрээнууд зэрэг ашигт малтмалуудын орд, илрэл, эрдэсжсэн цэгүүдтэй.

L-46-XVII хавтгайд асбест-1, боксит-1 орд, хүрэн нүүрс-1, асбест-4, гартаам-1, жонш-1, болор-1 илрэл, төмөр-3, зэс-26, никель-2, мышьяк-3 эрдэсжсэн цэг, молибден-11, цагаантугалга-8, ванади-8, титан-3, лити-2, хром-1, кобальт-1, циркон-3 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-46-XVIII хавтгайд алт-зэс-1, натрийн давс-1, шавар-3, шохойн чулуу-1, гантиг-2, бул чулуун хуримтлал-1 орд, хүрэн нүүрс-2, никель-1, зэс-3, алт-3, давс-1, мусковит-1, асбест-4, бал чулуу-3 илрэлүүд, төмөр-3 никель-1, зэс-1, алт-зэс-1, алт-8, цагаан алт-1 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-47-I хавтгайд фосфорит-1, элс-1, шохойжин-2, доломит-1, хайрга-1 ордтой, фосфорит-9, элс-3, доломит-1, элс, хайрга-1, төмөр-2, төмөр-зэс-1, зэс-1, цайр-хартугалга-1 илрэлтэй, хартугалга-9, вольфрам-2, зэс-5, зэс-хартугалга-4, алт-8, мөнгө-2, тори-1, молибден-7, хартугалга-11, цагаантугалга-1, ниоби-4, кобальт-1, никель-1 эрдэсжсэн цэгтэй, бари-3, молибден-9, хром-3, зэс-10, циркон-5, циркон-тори-1, цайр-3, мөнгө-6, цагаантугалга-4, берилли-2, вольфрам-8, молибден-цайр-2 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-47-VII хавтгайд молибден-1, барилгын элс-2, тоосгоны шавар-1, шохойжин-2 орд, барилгын элс-1, тоосгоны шавар-2, мусковит-1, болор-3, фосфорит-5, зэс-2, хартугалга-цайр-11, цайр-2, зэс-цайр-1, зэс-хартугалга-3 илрэл, фосфорит-2, зэс-5, алт-3, цайр-1, цайр-молибден-1, цайр-төмөр-1, зэс-цайр-1, титан-зэс-1, хартугалга-цайр-2, зэс-хартугалга-1, зэс-алт-1, хартугалга-мөнгө-1 эрдэсжсэн цэг, вольфрам-3, хартугалга-16, молибден-7, цагаантугалга-19, хром-1, мөнгө-2, циркон-4 сарнилын хүрээ тогтоогдсон.

L-47-XIII хавтгайд шохойжин-1, шавар-3, занар-2, хүчиллэг интрузив чулуулаг-1, асбест-1, магнезит-1, эрдсийн будаг-2, чулуун урлалын түүхий эд-2 орд, хүрэн нүүрс-3, төмөр-1, хром-2, зэс-3, хартугалга-1, хартугалга-цайр-1, алт-5, алт-зэс-2, элс-1, элс-хайрга-1, гоёл чимэглэлийн чулуу-3, асбест-6, тальк-1, магнезит-2, чулуун урлал-2, эрдсийн будаг-2, гипс-1 илрэл, төмөр-1, манган-1, титан-1, хром-14, зэс-молибден-2, зэс-алт-5, мышьяк-1, никель-3, молибден-3, хартугалга-3, хартугалга-цайр-5, вольфрам-1, алт-28, алт-зэс-3, цагаан алт-8, барит-3, төмөр-зэс-1, төмөр-цайр-1, хром-никель-3 эрдэсжсэн цэгүүд, зэс-31, мөнгө-1, кобальт-6, хром-39, цагаан алт-8, лити-1 сарнилын хүрээнд тогтоогдсон.

Эдийн засгийн хувьд: Судалгааны талбай нь Баян-Өлгий аймгийн Алтай, Дэлүүн, Булган сумдын нутагт, Ховд аймгийн Ховд, Дуут, Чандмань, Мөнххайрхан, Зэрэг, Булган, Үенч, Мөст, Цэцэг сумдын нутагт, Завхан аймгийн Ургамал, Сантмаргац, Эрдэнэхайрхан, Улиастай, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Дөрвөлжин сумдын нутагт, Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Тайшир, Алтай, Шарга, Дарви, Манхан сумдын нутагт хамаарагдана. Энэ талбай нь томоохон суурин газрууд /3 аймгийн төв/ хамрагдсан бөгөөд талбайн зарим хэсгээр нилээд алслагдсан, дэд бүтэц муу хөгжсөн бүсэд хамаарагдана. Төслийн талбайн баруун хэсэг нь Монгол Улсын хилийн бүс, зурвас газартай давхцана.

3. Ажлын зорилго:

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн судалгааны ажлын хамрагдах хүрээг нэмэгдүүлэх, түүнийг нарийвчлах, улс орны эдийн засаг, дэд бүтэц, бүс нутгийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тухайн бүс нутагт эрдэс түүхий эдийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, төрөл бүрийн ашигт малтмалын тархалт, байршлын зүй тогтолыг тодорхойлж, эрдэс баялгийн нөөцийн хэтийн төлвийг үнэлэх, хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал болон газрын хэвлийн ашиглалт, олборлох үйл ажиллагаа зэрэг асуудлыг зохицуулах, шийдвэрлэхэд суурь мэдээлэл болгон ашиглах үндсэн зорилготой.

Ховд-2020 талбайн хэмжээнд гүйцэтгэх 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сувгийн /соронзон, уран, тори, кали, нийлбэр/ судалгааны ажлын үр дүнд ижил утгуудын зургуудыг зохиож, төслийн талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын ерөнхий зүй тогтолтой нь холбон геологи-геофизикийн тайлал хийж, тайлбар бичгийн хамт үйлдсэн байна.

4. Судалгааны ажлын зорилтыг шийдвэрлэх үндсэн арга аргачлал ба дэс дараалал:

А. Бэлтгэл үе:

4.1. Судалгааны ажлын төсөл, төсөв, календарьчилсан төлөвлөгөө зохионо.

4.2. Талбайн хэмжээнд өмнө нь хийж гүйцэтгэсэн геологи, геофизикийн судалгааны болон сэдэвчилсэн судалгааны материалуудыг судлан танилцаж, дүн шинжилгээ хийн дүгнэж, судалгааны арга аргачлалыг сонгох, дүгнэлт өгнө. Үүнд:

- Өмнөх бүх төрлийн судалгааны ажлын үр дүнг багтаасан баримт материалын зургийг зохиож бүртгэл үйлдэх,
- Төслийн талбайн хэмжээнд мэдэгдэж байгаа бүх төрлийн ашигт малтмалын орд, илрэлийн бүртгэл үйлдэн 1:200000-ны масштабтай тойм зураг зохиох,
- Өмнө нь хийгдсэн агаарын болон газрын геофизикийн бүх шатны судалгааны ажлын материалыг боловсруулан дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулан хээрийн судалгааны ажлыг урьдчилсан байдлаар төлөвлөх.

4.3. Судалгааны ажлыг явуулахад шаардлагатай эрх зүйн холбогдолтой (орон нутаг, нислэг үйлдэх зөвшөөрөл, хил хамгаалах газраас авах зөвшөөрөл, тусгай хамгаалалттай газарт ажиллах зөвшөөрөл гэх мэт) бүх баримт бичгүүдийг бүрдүүлсэн байна.

4.4. Техник, тоног төхөөрөмж болон ажиллагсдын хөдөлмөр ахуйн нөхцлийг хангахад чиглэсэн хээрийн судалгааны өмнөх бэлтгэл ажлуудыг бүрэн хангана.

Б. Хээрийн ажлын үе:

4.5. Хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө жил бүрийн хээрийн судалгааны ажлыг хэрхэн ямар хугацаанд гүйцэтгэхийг заасан ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө (ажлын хөтөлбөр) зохиох,

4.6. Судалгаанд хамрагдах талбайн хэмжээнд геологи, ашигт малтмалын тойм судалгаа (танилцах маршрут) явуулах,

4.7. Судалгааны талбайн газрын гадаргын хотгор, гүдгэрээс хамааран 70-350м-ийн өндөрт нислэг хийх ба нислэгийг геологийн структур, уул нуруудын суналд хөндлөн чиглэлээр гүйцэтгэж, нислэгийн газар зүйн холболтыг өндөр нарийвчлалын GPS ашиглан гүйцэтгэх,

4.8. Хээрийн судалгааны ажлын үед талбайд соронзон орны хувьслын болон GPS-ын суурин станцыг ажиллуулах,

4.9. Петрофизикийн судалгааны ажлаар тухайн талбайд тархсан чулуулгуудын хэмжээнд нягт болон соронзон мэдрэх чадварын хамт тодорхойлох,

4.10. Төслийн талбайн хэмжээнд хийгдсэн агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны ажлын үр дүнгээр тогтоогдсон гажлуудыг газар дээр нь геологийн эрлийн маршрут /дагалдах дээжүүдийн хамт/, соронзон, спектрометр, албадмал туйлшралын аргыг хэрэглэн эрэл шалгалтын ажлаар шалгах.

В. Суурин боловсруулалт:

4.11. Завсрын суурин боловсруулалт:

- Хээрийн судалгааны ажлын үед үе шаттайгаар анхан шатны боловсруулалтыг хийж тухайн жилийн геологи, геофизикийн хээрийн судалгааны ажлыг дүгнэх, шаардлагатай гэж үзвэл хээрийн хэмжилтийг дахин гүйцэтгэх арга хэмжээ авах.
- Хээрийн судалгааны ажлын үр дүнд шаардлага хангасан мэдээлэл өгч чадаагүй тохиолдолд судалгааны арга аргачлалыг өөрчлүүлэх хүртэл саналыг тухайн үед нь холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

4.12. Төслийн эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалт:

- Агаарын геофизикийн судалгааны ажлын үр дүнд соронзон орны, тори, уран, кали, эдгээрийн нийлбэрийн ижил утгын зургуудыг 1:200000-ны масштабаар Geosoft Oasis Montaj программ болон холбогдох бусад программ хангамжаар зурж боловсруулах,
- Геофизикийн чанарын болон тоон тайлалыг хийж өмнөх судалгаагаар хуримтлагдсан геологи, геофизик, геохимийн зэрэг холбогдох материалыг нэгтгэн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судалгааны талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын ерөнхий зүй тогтол, хэтийн төлөвтэй байж болох талбайнуудыг харуулсан зураг, бичвэрийн хамт зохиож ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах.

5. Ажил гүйцэтгэх хугацаа:

5.1. Төсөл, төсөв зохион батлуулах:

Эхний жилд: Шууд гэрээгээр

5.2. Хээрийн ажил:

Эхний жилд: Шууд гэрээгээр.

Хоёр дахь жилд: 2021 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

Гурав дахь жилд: 2022 оны 5-р сараас 10-р сарыг дуустал.

5.3. Суурин боловсруулалтын ажил:

Завсрын суурин боловсруулалт:

2020 оны 11-р сараас 2020 оны 4-р сарыг дуустал.

2021 оны 11-р сараас 2022 оны 4-р сарыг дуустал.

Эцсийн суурин боловсруулалт:

2023 оны 9-р сарын 30 хүртэл

5.4. Судалгааны ажлын үр дүнгийн тайланд хөндлөнгийн шинжээчээр шүүмж хийлгэх, холбогдох засвар, өөрчлөлтийг хийх:

2023 оны 10-р сарын 31 хүртэл

5.5. Геологийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж, мэргэжилтнээр хянуулж шаардлагатай засвар өөрчлөлтүүдийг хийсний үндсэн дээр ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр албажуулан ирүүлэх:

2023 оны 12-р сарын 31 дуустал.

5.6. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт, эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулсны дараа Геологийн баримтын төв архивт тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр, зургуудыг хуулсан дискийн хамт тушаах:

Эрх бүхий байгууллагын шийдвэр гарсаны дараа ажлын 5 хоногт багтаах